# НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР "АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулах хөрөнгө мян/төг | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг:<br>а/байгууллагын албан ёсны цахим хуудас;<br>б/сошиал сувгууд;<br>в/дотоод сүлжээ;<br>г/хэвлэл мэдээллийн хэрэгсэл;<br>д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц;<br>е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | -Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх;<br>-Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх;<br>-Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;<br>-Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших. | 2025.04.04<br>2025.06.06 | Сар бүр цахим хуудсанд байршуулах | 0 | АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас зэргийг "Нийслэлийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Газар" фэйж хуудсаар дамжуулан давхардсан тоогоор 5 видео, 9 постерийг байршуулж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулан нэг мэдээ дунджаар 2000-3000 хүний хандалт авсан байна.<br> | 100% |
| | | 1.2.Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нэлттэй | -Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; | Жилдээ | 2 өдөрлөг, 1 аян | 0 | Хугацаа болоогүй | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | -Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>-Хамтран ажилласан байгууллага, хүний тоо;<br>-Үр дүнг тооцсон байх. | | | | | |
| | | 1.3.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий зидео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | -Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>-Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>-Олон нийтэд түгээсэн байх. | 2025.04.04<br>2025.06.06 | 12-оос доошгүй | 0 | Өөрийн байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан 3 төрлийн зурагт хуудас бэлтгэн байгууллагын пэйж хуудас, https://erp.ulaanbaatar.mn/ системд нийтэлж, олон нийтэд хүргэж ажилласан.<br> | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | 2.1.Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах;<br>-Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;<br>-Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | Жилдээ | 2-оос доошгүй | 0 | Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд сурталтай холбоотой гомдол мэдээлэл ирээгүй ба иргэдээс 93 өргөдөл гомдол, албан хаагчдаас 21 хүсэлт ирснийг цаг тухайд нь бүртгэн шилжүүлж, 93 өргөдөл гомдлын 84-ийг нь шийдвэрлэж, 60 өргөдөл гомдолд албан бичгээр, 5 өргөдөл гомдолд утас болон мессежээр хариу өгсөн ба өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 14 цаг байна.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар өргөдөл гомдол шийдвэрлэлтийн явцад өдөрт нь багтаан хүлээн аваагүй 2, явцын тэмдэглэл хугацаанд нь хөтлөөгүй 2, нийт 4 зөрчил бүртгэгдсэн ба хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй байна.<br>2024 оны эхний хагас жилд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцад 9 зөрчил бүртгэгдсэн ба зөрчил 44,4%-иар буурсан. | 100% |
| 3. | 3.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй | -Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс | Жилдээ | 4-оос доошгүй | 0 | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар онлайн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | арилгуулах арга хэмжээ авах | цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | судалгаа, санал асуулга авах;<br>-Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>-Хэрэгжилтийг тайлагнах. | | | | бизнес төвөөр хүсэлт ирүүлсэн хүнсний худалдааны 750, хоол үйлдвэрлэлийн 532 аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж ажилласан байна. | |
| | | 3.2.Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | -Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших;<br>-Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>-Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх. | Жилдээ | Тухай бүр | 0 | "2025 онд байгууллагын үйл ажиллагаанд хийх дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө"-г боловсруулан батлуулсан. Тус төлөвлөгөөний дагуу:<br><br>1.2025 оны I-р улиралд Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01 дугаартай удирдамжийн хүрээнд Хан-Уул, Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт ажиллаж байгаа улсын (ахлах) байцаагчдын ажлын цаг ашиглалт, цаг бүртгэл болон гадуур ажлын дэвтэр хөтлөлтөд 03 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 03 дугаар сарыг дуустал хугацаанд хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг нэгтгэн удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажилласан.<br><br>2.2025 оны II-р улиралд газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаартай удирдамжийн хүрээнд Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт ажиллаж байгаа улсын (ахлах) | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байцаагчдын өргөдөл, гомдол, албан бичиг шийдвэрлэлтэд 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарыг дуустал хугацаанд хяналт шалгалт хийн, дүнг нэгтгэн газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулан албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацааг багасгах зөвлөмжийг гарган ажиллаж байна. | |
| | | 3.3.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах | -Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналтыг тогтмол хийж хэвшсэн байх. | Жилдээ | | 0 | 2025 онд төсөв 4,589,116,600 төгрөгөөр батлагдаж, хөтөлбөр арга хэмжээний дагуу үйл ажиллагааны нөхцөл байдалтай уялдуулан зарцуулж байна. 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,725,650,200 төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан байна.<br>2025 оны батлагдсан төсөвт 32,000,000 төгрөгийг зардлын бүлэг хооронд шилжүүлсэн байна.<br>Газрын хэвийн үйл ажиллагааг хангахад 2025 онд санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангасан 1,371,896,668.86 төгрөгийн ажил гүйлгээний зарцуулалтыг данс бүртгэлд тусган ажиллаж байна.<br>НХХААГазарт бүртгэлтэй 6 авто тээврийн хэрэгслийг АТБӨЯХАТатварт 659,568 төгрөг, зам ашигласан төлбөр 775,000 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөг, агаарын бохирдол 40,400 төгрөг, оношлогоонд 88,000 төгрөг, ЖХДаатгалд 585,792 төгрөг тус тус төлж хамруулсан байна.<br>Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд 2025 оны 01-06 сарын байдлаар 23 нэр төрлийн 79 мэдээлэл оруулахаас 79 мэдээлэл оруулж нийтэд ил тод болгосон байна. | |
| | | 3.4.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах | -шинээр томилогдсон албан хаагчдад сургалт зохион байгуулсан байх | Жилдээ | | 0 | Хугацаа болоогүй | |

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЭБАТ Б.БАЯНХУТАГ